



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Компанийн 2022 оны үйл ажиллагааны
тайлангийн тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, Багануур ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Багануур ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Үйл ажиллагааны тайланг 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр болох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.
3. ТУЗ-ийн гишүүдээс компанийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан санал, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.ЦЭВЭГЖАВ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн
тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Компаний тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 76 дугаар зүйлийн 76.1.11, 96 дугаар зүйлийн 96.5, “Багануур” ХК-ийн дүрмийн 10.3.11 дахь заалт, Тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын байгууллагын өгсөн дүгнэлт, зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт, зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмж, албан шаардлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган, холбогдох дүрэм, журмыг сайжруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан тэнцлийг зүйтэй гэж үзэж хавсралт ёсоор хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэн батлуулсугай.
3. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдын ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б.ЦЭВЭГЖАВ/

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 2-р дүгээр сарын 21-ны
өдрийн 2023/01 дугаар тогтоолын
хавсралт



2022 оны тайлан тэнцэл

Багануур ХК-ийн 2022 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг
255,838.3 сая төгрөг, үүнээс

- 2.1.1. Эргэлтийн хөрөнгийг 70,647.2 сая төгрөг
- 2.1.2. Биет үндсэн хөрөнгийг 151,858.9 сая төгрөг
- 2.1.3. Биет бус хөрөнгийг 4,358.2 сая төгрөг
- 2.1.4. Урт хугацаат хөрөнгө оруулалтыг 999.76 сая төгрөг
- 2.1.5. Уул уурхайн хөрөнгийг 27,209.7 сая төгрөг
- 2.1.6. Хойшлогдсон татварын хөрөнгийг 764.3 сая төгрөг
- 2.2 Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүнг 255,838.3 сая төгрөг
 - 2.2.1. Богино хугацаат өр төлбөрийг 164,935.2 сая төгрөг
 - 2.2.1. Урт хугацаат өр төлбөрийг 56,666.6 сая төгрөг
 - 2.2.2. Хувьцаа эзэмшигчийн өмчийн дүн 2,097.4 сая төгрөг
 - Үүнээс: Төрийн өмчийн дүнг 1,573.0 сая төгрөг
 - 2.2.3. Хуримтлагдсан алдагдал 28,546.4 сая төгрөг
 - 2.2.4 Тайлант үеийн алдагдал 33,684.2 сая төгрөг

---oOo---



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Ажиллагсдад жилийн үр дүнгийн
шагнал олгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, 43 дугаар зүйлийн 43.1.3, “Багануур” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.20, Геологи, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээр, “Багануур” ХК болон Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээ, гүйцэтгэх захирлын 2011 оны Б/41 дугаар тушаалаар батлагдсан ажиллагсдад “Жилийн үр дүнгээр шагнал олгох журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг “Жилийн үр дүнгийн шагнал” олгох журмын шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэж үзсэний дүнд гурван сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний жилийн үр дүнгийн шагнал олгохыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д зөвшөөрсүгэй.
2. Жилийн үр дүнгийн шагнал цалингийн эх үүсвэрийг зохих зардлаас гаргахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.ЦЭВЭГЖАВ



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Охин компаниудын Төлөөлөн удирдах
зөвлөлийг татан буулгах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

Нэг. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дүрмийн өөрчлөлтийн дагуу “Багануур” ХК-ийн охин компани болох “Багануур Сувилал” ХХК, “Багануур Илч” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг татан буулгасугай.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийг татан буулгаж байгаатай холбогдуулан охин компаниудын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан зохих журмын дагуу бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Д.Түвшинжаргал)-д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.ЦЭВЭГЖАВ